



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

- Иргэний нисэхийн хяналт зохицуулалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дотоод хяналт, Чикагогийн Конвенцын 13 дугаар Хавсралтад тусгаснаас бусад төрлийн зөрчил, тохиолдлуудыг шинжлэн шалгаж, тайлан дүгнэлт гаргах, хэрэгжилтэд хяналт тавих, иргэний нисэхийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, төсөл боловсруулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлж байгаа бодлого, чиг хандлагад нийцүүлэн Монгол Улсын иргэний нисэхийн салбарын аюулгүй ажиллагааны удирдлагын баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, аюулгүй байдлын мэдээллийн санг хөтлөх;
- Байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах;
- Агаарын тээврийн үйл ажиллагаа, агаарын хөлгийн техникийн үйлчилгээний аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтыг хангуулах;
- Агаарын навигаци, аэродром, нисэх буудлын аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтыг хангуулах;
- Агаарын навигаци, нисэх буудал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний үр ашиг, чанар, хүртээмжийг сайжруулах, хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хувилбар боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах;
- Нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, харилцагчийн эрх ашгийг хангасан, өрсөлдөөнийг дэмжсэн, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн агаарын тээврийг үе шаттай хөгжүүлэх бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал боловсруулах, батлагдсан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохицуулах;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, эрх зүйн туслалцаа үзүүлэх;
- Төсвийг үр ашигтай зарцуулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх.